

2

БҮЛЭГ

Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж

2.1. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж

2.1.1. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объект

2.1.2. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объект тал

2.1.3. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект

2.1.4. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал

2.2. Хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүн

2.3. Хүн худалдаалах гэмт хэргийг төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх нь

2.4. Хүн худалдаалах гэмт хэргийг гадаадын зарим орнуудын Эрүүгийн хууль тогтоомжуудад хуульчилсан байдлыг харьцуулан судлах нь



БОДЛОГО, ДАСГАЛ

Бодлого 1

Дорж 10-р ангид суралцдаг, 17 настай, түүний найз Төрөө 18 настай. Нэг өдөр Төрөө Доржид “Царайлаг охидыг хил гаргаж худалдаалбал их мөнгө олно. Чи мөнгөтэй л бол болчихвол АНУ явж сайхан амьдрах боломжтой” гэж хэлжээ.

Дорж ч мөнгө олох хамгийн хялбар арга бол хүн худалдаалах гэж бодоод 2 охиныг хууран мэхэлж, хил гаргах гэж байгаад цагдаагийн байгууллагад баригджээ.

Асуулт:

- 1. Доржид эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй юу? Дорж эрүүгийн хариуцлага хүлээх Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн үү?*
- 2. Төрөөгийн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй юу? Хэрэв үндэслэлтэй бол гэмт хэрэгт хамтран оролцогчдын аль нь вэ?*

Бодлого 2

Бат БНХАУ-ын иргэн Ли-д өгөх мөрийтэй тоглоомын өрөндөө Цэцэг гэгч эмэгтэйг хил гарган Ли-д худалдаалахаар түүний гэр бүлийнхнийг ална гэх мэтээр удаа дараа сүрдүүлсний улмаас Цэцэг худалдаалагдахыг зөвшөөрч, Батын хамт БНХАУ руу явжээ.

Асуулт:

- 1. Батад эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй юу? Хэрэв үндэслэлтэй бол Батад Монгол улсын Эрүүгийн хуулийн ямар зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх вэ?*
- 2. Цэцэгийн худалдаалагдахыг зөвшөөрсөн нь Батыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болох уу?*

Бодлого 3

Казахстанд 500-1000 долларын цалинтай, орон байр, хоол, хувцасаар хангах барилгын ажилд зуучилна гэсний дагуу бид явцгаасан юм. Очтол байдал өөр байсан. Биднийг эндээс авч явсан хүн нэг хүнийг 400 доллараар бодож, тэндэхийн боссуудаас мөнгө авсан гэсэн. Биднийг тэнд хүлээж авсан хүн бичиг баримтуудыг хураан авч, ямар ч цалин хөлсгүйгээр ажиллуулж, өдөрт нэг удаа ногоо голдуу хоол өгч, өвлийн хүйтэнд төмөр контейнерт байлгаж, маш харгис хэрцгий ханддаг байсан. Ямар нэг байдлаар эсэргүүцвэл “ална” гэж сүрдүүлдэг байсан. Би тэндээс оргож, Монгол улсын Элчин сайдын яаман дээрээ очиж, улмаар Монголдоо ирсэн.

Асуулт:

- 1. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй юу?*
- 2. Энэхүү иргэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөн үү?*